

Хятад хэлний үйлийн тооллого үг ба сурах бичиг дэх тооллого үгийн судалгаа

Баярсайхан Цэцэгбадам 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Дорно дахины хэлний тэнхимийн багш, Магистр, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-03-29

Засварласан - Revised:
2024-04-18

Хэвлэгдсэн - Published:
2023-05-25

tsetsegbadam@msue.edu.mn

ORCID:[0009-0003-2416-5870](https://orcid.org/0009-0003-2416-5870)



© 2024, Author(s)

Хураангуй: Орчин цагийн хятад хэлний тооллого үг тухайн хэлний үгсийн аймгийн нэгэн онцлог бүхий тогтолцоо төдийгүй төрөл, тоо хэмжээнээс шалтгаалан хэрэглээний хувьд өөр өөр байдаг. Хятад ард түмэн аливаа юмс үзэгдлийг зайлшгүй хэм хэмжүүрээр илэрхийлж ирсэн нь бусад орны хэл, соёлоос ялгарах нэг онцлог болдог. Өөр өөр орчин нөхцөлд хэрэглэдэг 600-гаад төрлийн тооллого үг байдаг гэсэн судалгааг Хятадын нэрт эрдэмтэн, судлаач Гуо Шяньжэнь 2002 онд өөрийн бүтээлдээ дурдсан байдаг.

Хятад хэлний нэрийн тооллого үг нь нэр үг, үйлийн тооллого үг нь үйл үгтэй хоршин хэрэглэгддэг энэхүү онцлог шинж чанар нь хятад хэл суралцагчдын хувьд томоохон бэрхшээл болдог учир тооллого үгийн тухай, ялангуяа үйлийн тооллого үг, хэрэглээний бүтэц, сурах бичиг дэх үйлийн тооллого үгийн судалгааг хураангуйлан та бүхэнд хүргэхийг зорилоо.

Судалгааны үр дүнд МУБИС-ийн хятад хэлний мэргэжлийн ангид судалж буй анхан шатны сурах бичигт давтагдсан хэлбэрээр 4 үйлийн тооллого үг илэрч байхад дунд шатны сурах бичигт давтагдсан хэлбэрээр 16 үйлийн тооллого үг илэрч байна.

Түлхүүр үг: хятад хэл, үйлийн нэгж үг, сурах бичиг, судалгаа

Удиртгал

Тооллого үгээрээ хамгийн баялаг хэлний нэг бол яахын аргагүй хятад хэл билээ. Гуо Шяньжэнь 1987 “Орчин цагийн хятад хэлний тооллого үгийн хэрэглээний толь бичиг” бүтээлдээ хятад хэлний тооллого үгийг нэгтгэн, мөн утга, хэрэглээг тус бүтээлдээ тусгасан байдаг. Тэрээр уг бүтээлдээ хятад хэлэнд 600 гаруй тооллого үгийг хураангуйлан нэгтгэсэнээс (Шяньжэнь, 2002) хойш өнөөг хүртэл албан ёсны тоо баримт хараахан гараагүй байна.

Хятад хэлний тооллого үгийг нэрийн тооллого үг, үйлийн тооллого үг гэж 2 төрөлд хуваадаг (Минкай, 2011). Хятад хэлний нэрийн тооллого үг нь үйлийн тооллого үгтэй харьцуулахад тоо болон хэрэглээ, хэрэглэгдэх давтамжаараа нэлээд уян хатан байдаг. Өөрөөр хэлбэл тооллого үгийн дийлэнх хувийг нэрийн тооллого үг эзэлдэг гэж дүгнэж болно. Харин үйлийн тооллого үгийн эзлэх хувь цөөн ч гэлээ бусад улс, үндэстний хэлтэй харьцуулахад бага биш юм.

Дараах жишээнээс нэрийн болон үйлийн тооллого үгийн ялгааг харж болно.

1. 我实在冒昧，我想在你那里讨一杯水喝。

Миний бие аймишиггүйгээр зориглон танай тэнд очиж аяга ус ууя.

2. 母亲在心里一次又一次地呼唤着女儿的名字，盼着她平安归来。

Эх сэтгэлдээ охиныхоо нэрийг дахин дахин дуудан түүнийг амар амгалан буцаж ирэхийг хүснэ.

Дээрх жишээнээс харахад нэрийн тооллого үг буюу “杯” (аяга) нь нэр үгтэй, “次” (удаа) нь үйл үгтэй хамт хэрэглэгдэж буйг мөн тооллого үг бүгд тооны нэртэй хоршин хэрэглэгдсэн нэг ижил талыг харж болно.

Энэхүү судалгаа нь харьцуулан дүн шинжилгээ хийх арга, эх сурвалжийг задлан шинжлэх арга, тоо баримтыг нэгтэн дүгнэх аргыг ашигласан ба МУБИС-ийн хятад хэлний багш мэргэжлийн ангид судалдаг анхан болон дунд шатны сурах бичгийг сонгон авч үйлийн тооллого үгийн тархалтыг судлан харьцуулж, хүснэгтээр нэгтгэн дүгнэн харуулахыг зорилоо.

БНХАУ-ын нэрт хэл судлаач, эрдэмтэн Гуо Шяньжэний “Орчин цагийн хятад хэлний тооллого үгийн хэрэглээ толь бичиг” –ийг үндсэн хэрэглэгдэхүүнээ болгон судалахын зэрэгцээ Бээжингийн хэлний их сургуулиас гадаад суралчдад зориулан гаргасан “Хөгжлийн хятад хэл” (анхан болон дунд шат) цуврал сурах бичиг дэх хятад хэлний үйлийн тооллого үгийн тархалтыг судаллаа.

Анхан шатнаас дунд шат хүртэлх сурах бичгийн 1 сэдэв хичээл бүрд ойролцоогоор 2 ба түүнээс дээш үйлийн тооллого үг илрэх боломжтой ба хэрэглээний тайлбарыг нэмэлтээр сурах бичигт тусгаагүй нь суралцагчдад хүндрэлтэй санагдах нь гарцаагүй юм.

Хятад хэлний үйлийн тооллого үгийн гарал үүсэл

Эртний хятад хэлний тооны үг үйл үгийн хамт үйлийн хэмжүүрийг илэрхийлдэг байсан ба аажмаар “动词+数词+动量词” буюу “үйл үг+тооны нэр+үйлийн тооллого” гэсэн бүтэц бий болж үйлийн хэмжүүрийг илэрхийлэх болсон байна. Тан гүрнээс хойш үйл хөдлөлийн нэгжийг илэрхийлэх “回 (huí)” “次(cì)” зэрэг тооллого үг аажмаар бий болж эхэлжээ (Ванли, 1980).

Лю Шыру (Шыру, Вэй Жинийн умард хойд үеийн нэгж үгийн судалгаа, 1965) Вэй Жинийн умард хойд үеийн үйлийн тооллого үгийг судалсан ба “Хятад хэлний үйлийн тооллого үг Вэй жиний 6 төрт улсын үед хэдийн бий болсон байна” гэж тэмдэглэсэн байдаг.

Зарим судлаачид Ян Божюнь, Хө Юэшы (Ян Божюнь, 2001) түрүү Чинь улсын үед бий болсон, Фү Минди (Минди, 1965) “匝(zā)”, “周 (zhōu)” гэсэн 2 тооллого үгийг судлан түрүү Сү улсаас Жоу чинь улсын үед үүссэн гэж үзсэн байна. Пань Юньжун (Юуньжун, 1982), Тан Юймин (Юймин, 1990) Хань гүрний үед бий болсон гэж үзэн дараах Тан гүрний утга зохиолд буй жишээгээр тайлбарлажээ.

1. 闭气不息七遍。(《内经上》) Bìqì bù xī qī biàn. (“Nèijīng shàng”)

Амьсгалаа 7 удаа түгжих. (“Nèijīng тэргүүн судар”)

2. 初敢言，侯击敝数十下，痛不耐言。(《居延汉简》123.58) Chū gǎn yán, hóu jī bì shù shí xià, tòng bù nài yán. (“Jū yán hàn jiǎn”123.58)

Анх ярьж зүрхлэхдээ хэдэн арван удаа цохиулж, үг хэлж чадахгүй болтлоо өвдөж байсан. дээрх 2 жишээнд “遍(biàn)” “下(xià)” нь үйл үгийн утгаа алдан өмнөх үйл үгийнхээ давтамжийг илэрхийлж, үйлийн тооллого үгийн үүргээр орсон ба Хань гүрний үед үүссэн гэж үзжээ. Шянши (Шянши, 1993) мөн “Хятад хэлний үйлийн тооллого үг Хань гүрний үед үүссэн ба “遍(biàn)”, “出

(chū)”, “过(guò)”, “通(tōng)” бүгд Хань гүрний үеийн зохиол бүтээлд илэрч байгааг тэмдэглэжээ.”

Хятад хэлний үйлийн тооллого үгийн талаар хятадын эрдэмтэн судлаачид багагүй судалгаа хийсэн бөгөөд дараах 4 төрөлд хувааж болно. Үүнд:

Тодорхойлолт

Хятадын олон олон эрдэмтэн, судлаач үйлийн тооллого үгийг судалахын зэрэгцээ зарим талаар одоог хүртэл нэгдмэл саналд хүрээгүй байдаг. Үүний нэг жишээ нь үйлийн тооллого үгийн тодорхойлолт юм. Эрдэмтэн судлаач бүр өөр өөрийн үзэл бодлоор тодорхойлсон байдаг боловч түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн цөөн тооны тодорхойлолтоос доор өгүүлье. Үүнд:

Жао Юуаньрэн (Юуаньрэн, 1979) “Үйлийн тооллого үг нь үйл хөдлөлийн давтамжийг илэрхийлэх ба зарим үед биеийн аль нэг хэсгийг илэрхийлсэн үг болон багаж хэрэгсэлтэй холбоотой үгээр илэрдэг.”

Ху Юйшу (Юйшу, 1981) “Үйлийн тооллого үг нь үйл үгтэй хамт хэрэглэгддэг ямагт үйл үгийн ард ордог.”

Жу Дөши (Дөши, Хятадын хэл зүй товчоон, 1984) “Үйлийн тооллого үг нь үйл хөдлөл бий болсон тоог илэрхийлэх ба үйл үгийн ард байрлаж тусагдахуун гишүүний үүрэг гүйцэтгэдэг.”

Хө же (Хө, 2001) “Үйлийн тооллого үгийг тусгай ба зээлдмэл гэж 2 ангилал ба үйл хөдлөл бий болох давтамж эсвэл үйл хөдлөл үргэлжлэх цаг хугацааг илэрхийлнэ.”

Лю Жешөн (Жешөн, 2003) “Үйлийн тооллого үг нь үйл хөдлөлийн хэмжүүрийг илэрхийлдэг тул тусгай, цаг хугацаа, зээлдмэл үйлийн тооллого үг багтана.”

Жинь Гүйтао (Гүйтао, 2007) “Үйлийн тооллого үг нь тооны үгтэй хамт хэрэглэгддэг ба үйл хөдлөлийн давтамж, цаг хугацаа, хэр хэмжээг хэмжих нэгж үгийг хэлдэг.”

Лю Юэхуа (Юэхуа, 2011) “Үйлийн тооллого үгийг зээлдмэл, тусгай гэж 2 ангилал ба үйл хөдлөл, үйл хөдлөлийн өөрчлөлтийн давтамжийг илэрхийлэх нэгж үгийг хэлнэ.”

Дээрх судлаачдын тодорхойлолтоос нийтлэг зүйл ажиглагдаж байгааг хураангуйлбал:

- Үйлийн тооллого үг үйл хөдлөлийн давтамж илэрхийлсэн нэгж үг
- Үйлийн тооллого үг үйл үгтэй хамт хэрэглэгдэж, үйл үгийн ард байрладаг
- Үйлийн тооллого үгийг тусгай, зээлдмэл гэж 2 ангилал гэсэн нийтлэг гэсэн ижил ойлголтыг харж болно.

Ангилал

Хятадын эрдэмтэд тооллого үгийн ангилал тэр дундаа нэрийн болон үйлийн тооллого үгийн ангилалд өөр өөрийн байр суурьтай байдаг. Хятад хэлний хэл шинжлэлд төлөөлөх байр суурь эзэлдэг эрдэмтийн ангилалыг дурдвал:

Лю Шырү (Шырү, Вэй, Жиний умард хойд төрт үеийн тооллого үгийн судалгаа, 1965) “Вэй Жиний умард хойд төрт үеийн тооллого үгийн судалгаа” бүтээлдээ тусгай ба зээлдмэл үйлийн тооллого үг гэж ангилсан байдаг. Түүний ангиллаар тусгай тооллого үгт “次、回、下、遍、趟、场 1、番、通、气、阵、顿、场2” (cì, huí, xià, biàn, tàng, chǎng 1, fān, tōng, qì, zhèn, dùn, chǎng 2)-ийг багтаан, зээлдмэл тооллого үгийг гарал үүслээр нь цаг хугацаа, эд эрхтэн, багаж хэрэгсэл, ижил хэлбэр, дагалдах үйлийн тооллого үг гэж 5 ангилжээ.

Люй Шушян (Шушян, 1999) “Хятадын хэлзүйн хураангуй” бүтээлдээ үйлийн тооллого үгийг тусгай, үйл хөдлөлийн багаж хэрэгсэл илэрхийлсэн зээлдмэл болон үйл үгийн нэгж илэрхийлсэн үйлийн тооллого үг гэж 3 ангилжээ.

Жу Дөши (Дөши, Хэл зүйн товхимол, 2011) судлаачийн ангилал Лу Шушян судлаачтай бараг ижил бөгөөд тэрээр тусгай, зээлдмэл, давтсан үйлийн тооллого үг гэж 3 ангилсан байдаг.

Ван Ли (Ли В. , 2011) “Хятадын орчин цагийн хэлзүй” бүтээлдээ илэрхийлж буй утгаар нь тоо илэрхийлсэн, өнө түүхтэй, гэнэтийн үйлийн тооллого үг гэж ангилсан бол шинж чанараар нь тусгай, зээлдмэл, салмал үйлийн тооллого үг гэж ангилсан байна.

Шао Жиньминь (Жиньминь, 1996) “Үйлийн тооллого үгийн утгын анализ ба түүний үйл үгийн сонголтын харьцаа” өгүүлэлдээ үйлийн тооллого үгийг зайлшгүй үйл үгтэй хамт судлах хэрэгтэйг дурдаад нийтлэг, бие даасан, зээлдмэл гэж 3 ангилжээ.

Үйлийн тооллого үгийн заах аргын судалгаа

Хө Хунянь (Хунянь, 2001), Лю Вэй (Вэй, 2013) нар хоёрдагч хэлний сургалтан дахь нэрийн тооллого үгийг хятад хэл суралцагчид хэрхэн сурч буйг сорил ашиглан судалжээ. Судалгаагаар тэд хятад хэл суралцагчид тооллого үгийг хэрэглэхэд гаргадаг алдааг нэгтгэжээ. Тан Ин (Ин, 2010), Ли Жя (Жя, 2012) хятад хэл суралцагчдын үйлийн тооллого үг сурч буй байдалд судалгаа хийжээ. Фөнли (Ли Ф. , 2013) солонгос суралцагчид үйлийн тооллого үг сурч буй байдалд судалгаа хийн тэдний гардаг алдаанд дүн шинжилгээ хийсэн байна. Ху Чингуо (Чингуо, 2012) асуулгын аргаар тооллого үг суралцаж буй байдалд судалгаа хийсэн ба суралцаж буй үр дүнг ихээс бага руу ангилсан ба нэрийн тооллого үг-үйлийн тооллого үг-зээлдмэл тооллого үг-давтамж ихтэй тооллого үг-давтамж багатай тооллого үг гэж хуваажээ. Лан Нин (Нин, 2015) “Хятад хэлний түвшин тогтоох дэсийн стандарт ба хэлзүйн дэсийн хөтөлбөр” дэх “次、回、遍、趟” (cì, huí, biàn, tàng)-тэй алдаатай өгүүлбэрүүдийг Төрийн хэлний хорооны орчин цагийн хятад хэлний сан, HSK-ийн зохион бичлэгийн сангаас судлан алдааг тодорхойлжээ. Жан Шяовэй (Шяовэй, 2015) хятад хэлний хөтөлбөр, сургалтын материал, багш нарын заах арга болон гаргадаг алдаанд тулгуурлан сурах бичиг боловсруулах, сургалтанд тохиолдож буй бэрхшээлийг шийдвэрлэх арга замын талаар санал дэвшүүлсэн байна.

Хятад хэлний үйлийн тооллого үгийн хэл зүйн бүтэц

Хятад хэлний тооллого үгийн нэг хэсэг болох үйлийн тооллого үгийн хэлзүйн хэлбэр түүхийн урт хугацаанд тасралтгүй өөрчлөгдөн боловсронгуй болсоор өнөөг хүрчээ. Үйлийн тооллого үг нь үндсэндээ тооны үгтэй хамт хэрэглэгддэг, үйл үгийн урд эсвэл ард байрлан өгүүлбэрт байц, нөхвөр гишүүний үүрэг гүйцэтгэдэг гэдгийг бид бүхэн мэднэ. Хэлзүйн бүтцийн хувьд дараах хэдэн төрөлтэй байна. Үүнд:

1. V+数+动量词 (үйл үг+тооны үг+үйлийн тооллого үг)

Энэ бол хамгийн түгээмэл хэлбэр, хэмжүүр болон цаг хугацааг хэмжсэн тооллого үг хэрэглэгддэг. Жишээ нь: “看一眼(нэг удаа харах), 跑一圈(нэг тойрог гүйх), 试一下(нэг удаа турших)” эдгээр нь ардаа төлөөний үг, нэр үг авахгүй. “看一眼他(kàn yīyǎn tā), 试一下大卫(shì yīxià Dà wèi)” гэж хэлж болохгүй. Харин төлөөний үгийг үйл үгийн ард, үйлийн тооллого үгийн урд, нэр үгийг үйлийн тооллого үгийн ард авдаг. Жишээ нь: “看你一眼(чамайг нэг удаа харах), 试一下小龙(Лууг 1 удаа турших)”. Үйл үг нь үйл хөдлөл илэрхийлсэн байх ба үйл үгийн ард “了” авч болно. Жишээ нь “摔了一下(хальтираад унах)”. Мөн энэ хэлбэр 2 тооны үг хэрэглэж болно. Жишээ нь “去了四五趟(4, 5 удаа явсан)”

2. V+代词+数词+动量词 (үйл үг+төлөөний үг+тооны үг+үйлийн тооллого үг)

Төлөөний үг өгүүлбэрт тусагдахуун гишүүн болох ба үйлийн тооллого үг, тооны үг 2

тусагдахуун гишүүний ард байрлан нөхвөр гишүүн болно. Үйл хөдлөл үргэлжилж буйг илэрхийлсэн үйл үг авдаг. Жишээ нь “见她两次(түүнийг 2 удаа харсан)”, “说你一通(чамайг хэсэг зэмлэх)”

3. V+数词+动量词+N (үйл үг+тооны үг+үйлийн тооллого үг+нэр үг)

Энэ бүтцэд хэрэглэгддэг цөөн тооны үйлийн тооллого үг байдаг ба “下、回、场、次、阵、趟、遍、顿、番、通” (xià, huí, chǎng, cì, zhèn, tàng, biàn, dùn, fān, tōng) зэрэг. Жишээ нь “哭一阵(нэг хэсэг уйлах)”, “吃三顿(3 удаа хооллох)”, “说一番(нэг удаа хэлэх)”. “N” нь юмс үзэгдлийг илэрхийлсэн нэр үг байна. Жишээ нь: “做一番研究(нэг судалгаа хийх)”

4. 数词+动量词+V (тооны үг+үйлийн тооллого үг+ үйл үг)

Үүргийн талаас нь харвал багаж хэрэгсэл, эд эрхтэн илэрхийлсэн үг үйлийн тооллого үг болдог. Үйл үг нь ихэвчлэн дан үетэй байх ба ардаа нөхвөр гишүүн авдаг. Жишээ нь: “一口吃完(нэг амьсгаагаар идэж дуусгах)”, “一步走过去(нэг алхмаар явж очих)”. Мөн хэмжүүр, цаг хугацаа илэрхийсэн үйлийн тооллого үг авч болно. Жишээ нь “一次下来(нэгмөсөн буух)”, “一天看完(нэг өдөрт уншиж дуусгах)”

5. 数+动量词+N+V (тооны үг+үйлийн тооллого үг+нэр үг+ үйл үг)

Үйлийн тооллого үг нь тооны үгтэй хамт хэрэглэгдэж тоо нэгжийн холбоо үг бүтээдэг. Өгүүлбэрт тодотгол гишүүн болох боловч төдийлөн түгээмэл хэрэглэгддэггүй. Энэ хэлбэр нь ихэвчлэн үгүйсгэсэн өгүүлбэрт хэрэглэдэг. Жишээ нь “一次课也没听(нэг хичээлд ч суугаагүй)”, “一场雨也没下(нэг ч бороо орсонгүй)”.

Үр дүн, хэлэлцүүлэг

Орчин цагийн хятад хэлний тооллого үгийн хэрэглээ толь бичигт нийт 629 тооллого үг байсан ба үүнээс үйлийн тооллого үг 103, үлдсэн хувийг нэрийн тооллого үг эзэлж байна.

Хүснэгт 1: Нэрийн болон үйлийн тооллого үгийн эзлэх хувь

Тооллого үг	Эзлэх хувь	Тоо
Нэрийн тооллого үг	84%	526
Үйлийн тооллого үг	16%	103

Дээрх хүснэгтээс хятад хэлний нэрийн тооллого үг нийт тооллого үгийн 84%, үйлийн тооллого үг үлдсэн 16%-ийг эзэлж байгааг харж болно.

Үүнээс гадна хятад хэлний тооллого үгийн толь бичигт орсон нийт тооллого үгийг бүтцээр нь ангилсаныг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 2: Хятад хэлний тооллого үгийн бүтэц

Бүтэц	Дан үет	Хос үет	3 үет	4 үет
Тоо	522	93	10	4

Үүнд нэг үет тооллого үг 522, хос үет тооллого үг 93, 3 үет тооллого үг 10, 4 үет тооллого үг 4 тус тус байна. Мөн дан үет тооллого үг нийт тооллого үгийн дийлэнх хувийг эзэлж байгаа ба хамгийн бага хувийг 4 үет тооллого үг эзэлж байна.

Хятад хэлний тооллого үгийн толь бичигт буй үйлийн тооллого үгийн жагсаалтыг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 3: Үйлийн тооллого үгийн жагсаалт

1	巴掌 bāzhāng	21	啖dàn	41	和hé	62	气qì	83	些xiē
2	把bǎ	22	刀dāo	42	记jì	63	强qiáng	84	星期xīngqī
3	拜bài	23	道dào	43	架jià	64	枪qiāng	85	旬xún
4	板bǎn	24	度dù	44	煎jiān	65	拳quán	86	巡xún
5	版bǎn	25	顿dùn	45	键jiàn	66	圈quān	87	眼yǎn
6	棒bàng	26	不bù	46	跤jiāo	67	日rì	88	夜yè
7	棒子bàngzi	27	耳光ěrguāng	47	脚jiǎo	68	任rèn	89	匝zā
8	辈bèizi	28	番fān	48	校xiào	69	晌shǎng	90	遭zāo
9	笔bǐ	29	斧子fǔzi	49	觉jué	70	声shēng	91	造zào
10	鞭biān	30	竿gān	50	局jú	71	丝sī	92	掌zhǎng
11	遍biàn	31	卦guà	51	开kāi	72	岁suì	93	仗zhàng
12	步bù	32	关guān	52	口kǒu	73	水shuǐ	94	折zhé
13	茬chá	33	个gè	53	扣kòu	74	胎tāi	95	周zhōu
14	场chǎng	34	滚gǔn	54	筷子kuàizi	75	堂táng	96	昼夜zhòuyè
15	锄chú	35	棍gùn	55	轮lún	76	天tiān	97	转zhuǎn
16	筹chóu	36	过guò	56	面miàn	77	趟tàng	98	壮zhuàng
17	锤chuí	37	合hé	57	年nián	78	通tōng	99	着zhe
18	捶chuí	38	赫兹hèzī	58	耙bà	79	下xià	100	阵zhèn
19	次cì	39	挥huī	59	拍pāi	80	响xiǎng	101	针zhēn
20	逮dài	40	回huí	60	炮pào	81	网wǎng	102	锥子zhuīzi
				61	盘pán	82	锨xiān	103	子儿zǐ er

Дээрх хүснэгтээс харвал “巴掌、棒子、辈子、耳光、赫兹、斧子、筷子、锥子、昼夜、子儿” (bāzhāng, bàngzi, bèizi, ěrguāng, hèzī, fǔzi, kuàizi, zhuīzi, zhòuyè, zǐ er) гэсэн хос үет үйлийн тооллого үгээс бусад нь дан үет үйлийн тооллого үг байгаа бөгөөд дийлэнх хувийг эзэлж буйг харж болно.

Монгол улсын их дээд сургуульд үздэг хятад хэлний аливаа сурах бичгүүдэд хэлзүйн тайлбар хэсэг чухал байр суурь эзэлдэг. Энэ нь суралцагчдад тухайн хэлний өгүүлбэрийн бүтэц, хэлзүйн бүрдүүлбэр хэсэг, хэрэглээг сайтар танин мэдэх, ойлгоход нь тус дөхөм болдог.

МУБИС-ийн Хятад хэлний багш мэргэжлийн 1-4 ангид үздэг сурах бичиг дэх үйлийн тооллого үг ба жишээг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4: Сурах бичиг дэх үйлийн тооллого үгийн судалгаа

№	Сурах бичиг	Үйлийн тооллого үг	Хичээл	Жишээ өгүүлбэр
1	初级口语 (I) Анхан шатны ярианы сурах бичиг	年nian (Шүхун, 2012)	23-р хичээл	我想再学习半年, 我正在办手续。 Би дахин хагас жил сурах гээд бичиг баримтаа бүрдүүлж байна.
2	初级综合 (I) Анхан шатны ерөнхий хятад хэлний сурах бичиг	年nian (Жихуа, 2011)	29-р хичээл	我刚学一年, 水平不高, 画的不好。 Би дөнгөж 1 жил сурсан тул түвшин доогуур, сайн зурдаггүй.
3	初级听力 (I) Анхан шатны сонсох чадварын сурах бичиг	下xia (Фэнгө, 2011)	11-р хичээл	你记一下我的手机号码。 Та миний утасны дугаарыг тэмдэглээд аваарай.
4		遍bian		我再说一遍。 Би дахин нэг удаа хэлье.
5		趟tang	28-р хичээл	王英, 太麻烦你了, 上午你就来了一趟, 下午又麻烦你了。 Ван Ин, танд төвөг болчихлоо, өглөө таныг 1 ирүүлээд орой дахиад л төвөг удчихлаа.
6	中级口语 (I) Дунд шатны ярианы сурах бичиг	声sheng (Хунбо, Хөгжлийн хятад хэл дунд шатны яриа I, 2011)	2-р хичээл	同学喊了一声“小姐”, 服务员就不太高兴。 “Эгч ээ” гэж ангийн хүүхэд нэг дуудтал зөөгч бага зэрэг уурлав.
7		枪qiang	4-р хичээл	要是老打一枪换一个地方, 你受得了吗? Хэрэв байнга газраа сольж буудаад байвал чи тэсэх үү?
8		下xia	6-р хичээл	很简单, 这是入会申请表, 请你填一下。 Их хялбар, энэ элсэлтийн маягт, та бөглөчих.
9	中级阅读 (I) Дунд шатны уншихын сурах бичиг	次ci (Чэнвэй, 2011)	2-р хичээл	母亲第一次坐了飞机, 第一次在儿子的陪伴下, 去了很远的地方。 Ээж анх удаа онгоцонд хүүгийн хамт суугаад алсыг зорилоо.
10		阵zhen	4-р хичээл	敲了一阵, 见没人出来, 就用身子一次又一次地向房门去。 Хэсэг тогшоод хүн гарч ирээгүй болохоор удаа бүр өөрийн биеэр үүдэнд нь очлоо.
11		口kou	5-р хичээл	我叹了一口气。 Би санаа алдлаа.
12		场chang		她自己留在家里, 听听音乐, 哭一场。 Тэр өөрөө гэртээ үлдээд хөгжим сонсоод нэг уйлав.
13		年nian	7-р хичээл	过了一年, 胡人入侵边塞, 健壮男子都拿起武器去作战。 1 жилийн дараа зэрлэгүүд хилийн цайз руу довтлон хүдэр чийрэг залуучууд зэвсэг барин тулалдав.
14		下xia		年轻人, 那我们就玩儿一下吧。 Залуу минь тэгвэл хоёулаа тоглоё.
15		眼yan	15-р хичээл	第二次他看了一眼, 又挂断了电话, 并向客户道歉说, 是他妈妈来的电话。

				Түүнийг 2 дахь удаагаа харахад утсаа таслан үйлчлүүлэгчээс уучлалт гуйгаад өөрийнх нь ээж залгасан гэж хэлэв.
16	中级口语 (II) Дунд шатны ярианы сурах бичиг	趟tang (Хунбо, Хөгжлийн хятад хэл дунд шатны яриа II, 2011)	3-р хичээл	好不容易回去一趟, 怎么不多待几天? 。 Арай гэж нэг оччихоод хэдэн өдөр яагаад байсангүй вэ?
17		下xia		你帮我看一下东西。Ta надад юмыг минь харж өгөөч.
18		顿dun	4-р хичээл	猴子看着猎人, 很久才明白过来, 猎人本来就是一顿美餐, 而且比笼子里的这块肉要丰盛很多。 Сармагчин анчинг хараад сая нэг ойлгов. Анчин сагсан дахь махнаас илүү их сайхан зоог юмсанжээ.
19		口kou	9-р хичээл	我必须一口气品尝20多种啤酒。Би заавал нэг амьсгаагаар 20 гаруй төрлийн шар айраг амталж үзнэ.
20		次ci	10-р хичээл	很多人第一次见面聊天儿, 常常问对方的一句话是“你是哪里人? ”。Олон хүн анх уулзаад нөгөө хүнээсээ “Чи хаанахынх вэ?” гэж асуудаг.
21		遍bian	15-р хичээл	对不起, 请再说一遍好吗? 。Өршөөгөөрэй, дахиад нэг удаа хэлж өгөөч.

Анхан шатны ерөнхий хятад хэлний сурах бичгийн 19-р хичээлд “遍” үйлийн тооллого үгийн хэрэглээг тайлбарласан байна. Харин бусад үйлийн тооллого үгийн хэрэглээг тайлбар дутмаг, гагцхүү сурах бичгийн эхэд тооллого үгийг илэрэхээс гадна дасгал хэсэгт үйлийн тооллого үг нөхөх, бичих зэрэг хэлбэрээр илэрч байна.

Дүгнэлт

1. Хятад хэлний үйлийн тооллого үгийн гарал үүслийн хувьд нэр үг болон үйл үгээс үүсэлтэйг харж болно. Бий болсон цаг хугацааны хувьд одоог хүртэл маргаантай байдаг бөгөөд нэгдмэл үзэл баримтлал байхгүй байна. Хятадын эрдэмтэн, судлаачид тооллого үгийн тодорхойлолт, ангилал болон заах аргын талаар ихээхэн судалгаа хийсэн нь эрдэм шинжилгээ, сургалт, арга зүйнүнэтэй хувь нэмэр оруулсан байна.
2. Хятад хэлэнд нийт 629 тооллого байдаг ба 103 нь үйлийн тооллого үг, үлдсэн 526 нь нэрийн тооллого үг байна. Бүтцээс нь харвал дан үет тооллого үг нэрийн болон үйлийн тооллого үгийн алинд ч дийлэнх хувийг эзэлж байна.
3. Хятад хэлний үйлийн тооллого үг 5 хэлбэртэй. Үүнд:
 - 1) V+数+动量词 (үйл үг+тооны үг+үйлийн тооллого үг)
 - 2) V+代词+数词+动量词 (үйл үг+төлөөний үг+тооны үг+үйлийн тооллого үг)
 - 3) V+数词+动量词+N (үйл үг+тооны үг+үйлийн тооллого үг+нэр үг)

4) 数词+动量词+V (тооны үг+үйлийн тооллого үг+үйл үг)

5) 数+动量词+N+V(тооны үг+үйлийн тооллого үг+нэг үг+үйл үг)

4. МУБИС-ийн хятад хэлний багш мэргэжлийн ангид үздэг сурах бичиг дэх үйлийн тооллого үгийн тархалтаас харахад дан үетэй тооллого үг байгаа бөгөөд зарим тооллого үг сурах бичгүүдэд давхцсан байгааг харж болно. Тухайлбал “下、口、年、次、遍、趟 (xià, kǒu, nián, cì, biàn, tàng)” юм. Эдгээр нь хятад хэлний давтамж өндөртэй тооллого үгэнд зүй ёсоор багтдаг. Түүнчлэн сурах бичгүүдэд үйлийн тооллого үгийн хэрэглээг тайлбарлаагүй нь багш сургалтандаа тусгайлан заах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

A study on the distribution of Chinese momentum words and quantifiers in teaching books

Tsetsebadam Bayarsaikhan

Department of Oriental Language, Mongolian National University of Education, Ulaanbaatar,
Mongolia

Abstract: Modern Chinese quantifiers are not only a unique system of Chinese parts of speech, but also differ in terms of usage due to differences in types, quantities, and other aspects. The Chinese people use a measure to represent anything or anything. This is one of the differences in language and culture compared to other countries. Famous Chinese linguist Guo Xianzhen mentioned in his 2002 work "Dictionary of the Usage of Quantifiers in Modern Chinese" that there are over 600 quantifiers used in different contexts in Chinese.

Chinese noun quantifiers are often paired with nouns, while Chinese momentum words are often paired with verbs. For Chinese language learners, this unique nature becomes a challenge. So, let Chinese learners understand Chinese quantifiers, especially momentum words, and let them understand the usage of momentum words. For the convenience of learning, we searched and summarized the momentum words in the Chinese teacher training course of Mongolian National Education University to share with everyone.

Keywords: Chinese, Verbs, Textbook, Research

Ном зүй

Шяньжэнь, Г. (2002). *Хятад хэлний тооллого үгийн хэрэглээний толь бичиг*. Бээжин: Хэл бичгийн хэвлэлийн газар.

Минкай, Г. (2011). *Хятад хэлний хэл зүйн онол*. Бээжин: Бизнесийн хэвлэлийн газар.

Ванли. (1980). *Хятад хэлний түүхэн эх*. Бээжин: Хятадын номын газар.

Шыру, Л. (1965). *Вэй Жинийн умард хойд үеийн нэгж үгийн судалгаа*. Бээжин: Хятадын номын газар.

Ян Божюнь, Х. Ю. (2001). *Эртний хятад хэлний хэл зүй ба түүний хөгжил*. Бээжин: Хэл бичгийн хэвлэлийн газар.

Минди, Ф. (1965). Үйлийн тооллого үг "匝(zā), 周(zhōu)" -ийн тухай. *Хятад улсын хэл бичиг*, 189.

- Юуньжун, П. (1982). *Хятад хэлний хэл зүйн түүхийн хураангуй*. Жөнжоу: Жунжоу ном, зургийн хороо.
- Юймин, Т. (1990). Эртний ярианы үг хэллэгийн тухайд. *Гуандун үндэстний дээд сургуулийн эмхтгэл*, 1-5.
- Шянши. (1993). *Хятад хэлний түүхийн товч хураангуй*. Бээжин: Дээд боловсролын хэвлэлийн газар.
- Юуаньрэн, Ж. (1979). *Хятад хэлний ярианы хэл зүй*. Бээжин: Бизнесийн хэвлэлийн газар.
- Юйшу, Х. (1981). *Орчин цагийн хятад хэл*. Шанхай: Шанхай боловсролын хэвлэлийн газар.
- Дөши, Ж. (1984). *Хятадын хэл зүй товчоон*. Бээжин: Бизнесийн хэвлэлийн газар.
- Же, Х. (2001). *Орчин цагийн хятад хэлний тооллого үгийн судалгаа*. Бээжин: Үндэсний хэвлэлийн газар.
- Гүйтао, Ж. (2007). *Сун, Юань, Мин, Чин гүрний үеийн үйлийн тооллого үгийн судалгаа*. Үхань: Үхань их сургуулийн хэвлэлийн газар.
- Юэхуа, Л. (2011). *Орчин цагийн хятад хэлний хэрэглээний хэл зүй*. Бээжин: Бизнесийн хэвлэлийн газар.
- Жешөн, Л. (2003). Орчин цагийн хятад хэлний үйлийн тооллого үгийн утгын онцлог, залоан шинжлэл. *Хэлний судалгаа*, 51-55.
- Шыру, Л. (1965). *Вэй, Жиний умард хойд төрт үеийн тооллого үгийн судалгаа*. Бээжин: Хятадын номын хороо.
- Шушян, Л. (1999). *Хятадын хэл зүйн хураангуй*. Бээжин: Бизнесийн хэвлэлийн газар.
- Дөши, Ж. (2011). *Хэл зүйн товхимол*. Бээжин: Бизнесийн хэвлэлийн газар.
- Ли, В. (2011). *Орчин цагийн хятад хэлний хэл зүй*. Бээжин: Бизнесийн хэвлэлийн газар.
- Жиньминь, Ш. (1996). Үйлийн тооллого үгийн утгын анализ ба түүний үйл үг сонгох харьцаа. *Хятадын хэл бичиг*, 100-109.
- Хуянь, Х. (2001). *Хятад хэлний үйлийн тооллого үгийн хэл зүй, утга, хэрэглээний онцлог*. Фүжоу: Фүжиянь багшийн их сургууль.
- Ин, Т. (2010). *Гадаад суралцагчд үйлийн тооллого үгийн нийлэмж сурч буй байдлын судалгаа*. Наньчан: Жианши багшийн их сургууль.
- Жя, Л. (2012). *Хятад дахь Индонез суралцагчдын хятад хэлний үйлийн тооллого үгийг сурч буй алдааны анализ ба заах аргын бодлого*. Чанша: Хунань багшийн их сургууль.
- Шяовэй, Ж. (2015). *Гадаад суралцагчдын хятад хэлний үйлийн тооллого үгийн сургалтын судалгаа*. Жинань: Шаньдуны багшийн их сургууль.
- Ли, Ф. (2013). *Солонгос суралцагчид хятад хэлний үйлийн тооллого үг сурч буй байдалд хийсэн судалгааны анализ*. Чанчунь: Жилиний их сургууль.

Вэй, Л. (2013). *Англи хэлтэй суралцагчид хятад хэлний нэрийн тооллого үг сурч буй байдлын судалгаа*. Наньжин: Наньжин их сургууль.

Чингуо, Х. (2012). Дунд, дээд шатны суралцагч хятад хэлний тооллого үг сурч буй судалгаа, анализ. *Хэлний сургалт ба судалгаа*, 48-54.

Нин, Л. (2015). Гадаад суралцагчдын хятад хэлний үйлийн тооллого үгийн алдааны анализ. *Зунь Ы багшийн дээд сургуулийн эмхтгэл*, 83-86.

Монгол, х. х. (2016). *Хятад хэлний үеийн галиг монгол хэлээр галиглах журам*. Улаанбаатар: Адмон ХХК.

Шүхун, В. (2012). *Хөгжлийн хятад хэл анхан шатны яриа I*. Бээжин: Бээжингийн хэлний их сургууль.

Жихуа, Р. (2011). *Хөгжлийн хятад хэл анхан шатны ерөнхий хятад хэл I*. Бээжин: Бээжингийн хэлний их сургууль.

Фэнгө, Ж. (2011). *Хөгжлийн хятад хэл анхан шатны сонсох I*. Бээжин: Бээжингийн хэлний их сургууль.

Хунбо, Л. (2011). *Хөгжлийн хятад хэл дунд шатны яриа I*. Бээжин: Бээжингийн хэлний их сургууль.

Чэнвэй, С. (2011). *Хөгжлийн хятад хэл дунд шатны яриа I*. Бээжин: Бээжингийн хэлний их сургууль.

Хунбо, Л. (2011). *Хөгжлийн хятад хэл дунд шатны яриа II*. Бээжин: Бээжингийн хэлний их сургууль.